

МОНОС ХҮНС ХК-ИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2026 оны 03 сарын 04-ны өдөр

№ 26/11

Улаанбаатар хот

Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг
зарлан хуралдуулах тухай

Компанийн тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.4, 59.10, 59.11 дэх заалт, 60 дугаар зүйл, 64 дүгээр зүйл, 65 дугаар зүйл, 67 дугаар зүйл, 71 дүгээр зүйл, 76 дугаар зүйлийн 76.1.2, 76.1.3 дахь заалт, Санхүүгийн зохицуулах хорооны “Хувьцаат компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлын зар хүргэх журам”, Компанийн дүрмийн 6 дугаар зүйлийн 6.4, 7 дугаар зүйлийн 7.1.2 заалтыг үндэслэн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн хурлын санал хураалтын дүнг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Монос хүнс ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг 2026 оны 04 дүгээр сарын 15-ны Лхагва гарагийн 14.00 цагт Улаанбаатар хот, Баянгол дүүрэг, 20-р хороо, Үйлдвэрийн баруун бүс, Сонсголонгийн зам гудамж 32/3 хаягт байрлах Монос хүнс ХК-ийн Эрүүл мэндийн хүнсний үйлдвэрийн 3 давхарт байрлах хурлын танхимд цахим, танхим хосолсон хэлбэрээр хуралдуулахаар шийдвэрлэсүгэй.
2. Хувьцаа эзэмшигчдийн хурлаар дараах асуудлыг хэлэлцүүлэхээр баталсугай. Үүнд:
 - 2.1. Компанийн 2025 оны санхүүгийн тайланд аудит хийсэн хөндлөнгийн компанийн аудитын дүгнэлтийг танилцуулах,
 - 2.2. Ногдол ашиг хуваарилах тухай Төлөөлөн Удирдах Зөвлөлийн хурлаас гарсан тогтоолыг танилцуулах,
 - 2.3. Компанийн 2025 оны үйл ажиллагаа, санхүүгийн тайланд өгсөн Төлөөлөн удирдах зөвлөлийн дүгнэлтийг хэлэлцүүлэх,
 - 2.4. Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2026 оны төсвийг хэлэлцүүлэх,
3. Хуралд оролцох эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах бүртгэлийн өдрийг 2026 оны 03 дугаар сарын 25-ны өдрөөр тогтоож, “Хувьцаа эзэмшигчдийн хурлын мэдэгдэл”-ийг холбогдох байгууллагад хууль тогтоомжид заасан хугацаанд хүргэсүгэй.
4. Хурлын зарыг тогтоолын Хавсралт №01-р батлан, компанийн болон Монголын Хөрөнгийн Биржийн цахим хуудас, өдөр тутмын хоёроос доошгүй хэвлэл мэдээллийн хэрэгслээр дамжуулан 2026 оны 03 дугаар сарын 09, 2026 оны 03 дугаар сарын 24-ний өдрүүдэд олон нийтэд зарлан мэдээлсүгэй.
5. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын даргаар ТУЗ-ийн хараат бус гишүүн Н.Улаанхүүг томилсугай.
6. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар хэлэлцэх асуудал, хурлаас гарах шийдвэрийн төсөл, түүнтэй холбогдох баримт бичгийг 2026 оны 03-р сарын 16-ны өдрийн дотор үнэт цаасны компанид цахим хэлбэрээр хүргүүлэхээр тогтоосугай.

7. Хурлын саналын хуудсыг энэ тогтоолын Хавсралт №02-р батлаж, үнэт цаасны компаниар дамжуулан хувьцаа эзэмшигчдэд тарааж, хуралд биечлэн оролцох боломжгүй хувьцаа эзэмшигчдээс саналын хуудсаар санал авах эцсийн хугацааг 2026 оны 04 дүгээр сарын 10-ны өдрөөр тасалбар болгосугай.
8. Хурал зохион байгуулах комиссын даргаар ТУЗ-ийн нарийн бичгийн дарга Н.Цагаанхүү, гишүүдээр маркетингийн албаны дарга Т.Энхжин, Олон нийттэй харилцах менежер Ч.Соёлжингоо, дижитал менежер И.Мөнхцэцэг нарыг томилсугай.
9. Дараах нэр бүхий хүмүүсийг хурлын Тооллогын комиссын бүрэлдэхүүнээр томилсугай.
Тооллогын комиссын даргаар санхүүгийн менежер П.Энхбаяр
Тооллогын комиссын гишүүдээр ЭБХА-ы дарга Ц.Дөлгөөнмайдар
санхүүгийн менежер М.Тамир
10. Хувьцаа эзэмшигчдийг хурлын материалтай танилцах нөхцөл, боломжийг бүрдүүлж, хуралд бэлтгэх, зохион байгуулах бэлтгэл ажлыг ханган ажиллахыг хурал зохион байгуулах комисс (Н.Цагаанхүү), Гүйцэтгэх захирал (А.Отгондарь) нарт даалгасугай.

ТУЗ-ИЙН ДАРГА



Х.АНАНД

2026 оны 03 дугаар сарын 04-ны өдрийн ТУЗ-ийн
хурлын 000000 тогтоолын Хавсралт № 01

/Хэвлэл, мэдээллийн байгууллагад хүргүүлэх зарын эх/

“МОНОС ХҮНС” ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН АНХААРАЛД

Монос хүнс ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал 2026 оны 04-р сарын 15-ны Лхагва гарагийн 14:00 цагт Улаанбаатар, Баянгол дүүрэг, 20-р хороо, Сонсголонгийн зам гудамж 32/3 хаягт байрлах Монос хүнс ХК-ийн Эрүүл мэндийн хүнсний үйлдвэрийн 3 давхарт байрлах хурлын танхимд цахим, танхим хосолсон хэлбэрээр хуралдах тул хувьцаа эзэмшигчид та бүхнийг урьж байна.

Хуралд оролцох эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах бүртгэлийн өдөр: 2026 оны 03-р сарын 25-ны өдөр

Хурлаар хэлэлцүүлэх асуудал:

1. Компанийн 2025 оны санхүүгийн тайланд аудит хийсэн хөндлөнгийн компанийн аудитын дүгнэлтийг танилцуулах
2. Ногдол ашиг хуваарилах тухай ТУЗ-ийн хурлаас гарсан тогтоолыг танилцуулах
3. Компанийн 2025 оны үйл ажиллагаа, санхүүгийн тайланд өгсөн ТУЗ-ийн дүгнэлтийг хэлэлцүүлэх
4. ТУЗ-ийн 2026 оны төсвийг хэлэлцүүлэх,

Хурлын материалтай танилцах:

1. Компанийн байранд ирж танилцах
2. Монос хүнс ХК-ийн <https://monosfoods.mn/> цахим хуудасны “Хувьцаа эзэмшигчдэд” талбарт нэвтрэн танилцах

Урьдчилан санал өгөх:

Хуралд биечлэн оролцох боломжгүй, урьдчилан санал өгөх хувьцаа эзэмшигч компанийн байранд өөрийн биеэр хүрэлцэн ирж өгөх, эсвэл баталгаат шуудангаар 2026 оны 04 сарын 10-ны өдрөөс өмнө ирүүлнэ үү.

Утас: 89943525, 89986609

ХУРАЛ ЗОХИОН БАЙГУУЛАХ КОМИСС

2026 оны 03 сарын 04-ны өдрийн ТУЗ-ийн
хурлын 26/11 тогтоолын Хавсралт № 02

**МОНОС ХҮНС ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН
САНАЛ АВАХ ХУУДАС**

Хувьцаа эзэмшигчийн овог нэр: _____

Регистрийн дугаар: _____

Эзэмшиж буй хувьцааны тоо (ширхэг) : _____

Бүртгэсэн ҮЦК-ийн нэр: _____

Бүртгэсэн брокерийн овог, нэр: _____

№	Хурлаас гарах шийдвэрийн томьёолол	Зөвшөөрсөн	Татгалзсан	Түдгэлзсэн
1	Монос хүнс ХК-ийн 2025 оны үйл ажиллагаа болон санхүүгийн тайланд ТУЗ-өөс өгсөн дүгнэлт			
2	Монос хүнс ХК-ийн ТУЗ-ийн 2026 оны төсөв			

Санал авах хуудсыг ашиглах санамж:

1. Хувьцаа эзэмшигч нь саналын хуудсыг бөглөхдөө санал өгөх хэсэгт (+ эсвэл √) тэмдэглэгээ хийнэ. Жишээ нь: Зөвшөөрсөн бол зөвшөөрсөн гэсэн нүдэнд дээрх тэмдэг тавина.
2. Саналын хуудсыг балласан, засварласан, тэмдэглэгээ хийгээгүй бол хүчингүйд тооцно.
3. Хувьцаа эзэмшигч нь өөрийн биеэр хуралд оролцож чадахгүй бол үнэт цаасны компани дээр очиж хурлын материалтай танилцан, саналын хуудсаа бөглөж 2026 оны 04 сарын 10 өдрөөс өмнө хүргүүлэх боломжтой.
4. Хэрэв өөр хүнээр төлөөлүүлэх бол тухайн төлөөлөх хүнд итгэмжлэл олгож нотариатаар баталгаажуулсан байх ба уг итгэмжлэл нь зөвхөн тухайн хурлын өдөр хүчинтэй байна.

Хувьцаа эзэмшигчийн гарын үсэг _____
_____/_____/_____

Саналын хуудсыг хүчинтэй/ хүчингүйд тооцсон:

Хүчингүйд тооцсон бол шалтгаан:

Тооллогын комиссын дарга: _____

Гишүүд: _____

СЗХ-ны 2018 оны 12 дугаар сарын 14-ний өдрийн
377-р тогтоолоор баталсан “Хувьцаат компанийн хувьцаа
эзэмшигчдийн хурлын зар хүргэх журам”-ын нэгдүгээр хавсралт

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН МЭДЭГДЭЛ

Компанийн нэр:	МОНОС ХҮНС ХК
Хаяг:	БГД, 20-р хороо Сонсголонгийн зам гудамж 32/3, Эрүүл мэндийн хүнсний үйлдвэр
Хурал хуралдах өдөр, цаг:	2026 оны 04 сарын 15, 14:00 цагт
Хурал хуралдах газар /хаяг, байршил/:	Улаанбаатар, Баянгол дүүрэг 20-р хороо, Сонсголонгийн зам гудамж 32/3, Монос хүнс ХК-ийн Эрүүл мэндийн хүнсний үйлдвэрийн 3 давхрын хурлын танхимд
Хурлын төрөл:	Ээлжит
Хурал зарлагч:	ТУЗ
Хурал хуралдах шийдвэр гаргасан огноо:	2026 оны 03 сарын 04
Олон нийтэд зарлах огноо:	2026 оны 03 сарын 09
Бүртгэлийн өдөр:	2026 оны 03 сарын 25
Хурлын баримт бичгийг БДК-д хүргүүлэх огноо:	2026 оны 03 сарын 16
Хүргүүлсэн огноо:	2026 оны 03 сарын 16
Хурлын даргын нэр:	ТУЗ -ийн хараат бус гишүүн Н.Улаанхүү
Тооллогын комиссын дарга, гишүүдийн нэр:	Дарга П.Энхбаяр Гишүүд Ц.Дөлгөөнмайдар, М.Тамир
Баримт бичгийн жагсаалт	1. Монос хүнс ХК-ийн ХЭ-ийн ээлжит хурлыг зарлан хуралдуулах тухай ТУЗ-ийн 2026-03-04 өдрийн тогтоол 2. ХЭ-ийн хурлын зарын загвар 3. Монос хүнс ХК-ийн 2025 оны үйл ажиллагааны тайлан 4. Монос хүнс ХК-ийн 2025 оны санхүүгийн аудитлагдсан тайлан 5. Монос хүнс ХК-ийн ТУЗ гишүүдийн танилцуулга 6. Компанийн ТУЗ-ийн 2026 оны төсвийн санал 7. Компанийн болон бүтээгдэхүүний танилцуулга /товхимол/ 8. ХЭ-ийн хурлын дэг 9. ХЭ-ийн хурлын саналын хуудас 10. ХЭ-ийн хурлаас гарах шийдвэрийн төсөл
Баримт бичгийн хуудасны тоо:	 хуудас

ХУРАЛ ЗОХИОН БАЙГУУЛАХ КОМИССЫН ДАРГА

 /Н.ЦАГААНХҮҮ/
 2026 оны 03 сарын 04 өдөр